

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2023 ОНЫ 09 ДҮГЭЭР САРД
ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭ**

2023.09.05/ Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит бус 13 дугаар хуралдааныг зохион байгуулсан. Хуралдаанаар:

1. “Анагаахын боловсрол олгох сургалтын байгууллагын хөгжлийг дэмжих” аймгийн зорилтот хөтөлбөр батлах тухай
2. Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06/05 дугаар тогтоолыг хүчингүй болгох тухай
3. “Говь консалтинг менежмент” ОНӨААТҮГ-ын дүрмийг шинэчлэн батлах тухай
4. Сонгуулийн хороог татан буулгах тухай
5. “Дорноговь орон сууц” ОНӨААТҮГ-ыг татан буулгах тухай
6. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох эсэхэд санал авах тухай
7. Газрыг улсын тусгай хэрэгцээнд шинээр авах, өөрчлөх, гаргах тухай /хаалттай хуралдаанаар хэлэлцэх/ асуудлуудыг хэлэлцэн 8 тогтоол батлсан гаргасан.

/2023.09.08/ Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг хүндэтгэх, тэдний гэгээн дурсгалыг мөнхжүүлэх өдрийг угтан "МОНГОЛ УЛСАД ГАРСАН УЛС ТӨРИЙН ХЭЛМЭГДҮҮЛЭЛТ, ДҮГНЭЛТ, СУРГАМЖ" сэдвээр Политехник коллежийн оюутнууд, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад мэдээлэл өгч, ярилцлагыг зохион байгуулсан.

Мөн энэхүү сэдвээр ахлах ангийн сурагчдын дунд "АХА" тэмцээнийг зохион байгуулсан. Тус тэмцээнд:

Тэргүүн байр: Сайншанд сумын ЕБС-ийн 5 дугаар сургуулийн 10Г ангийн сурагч С.Мишигдорж

Дэд байр: Сайншанд сумын ЕБС-ийн 2 дугаар сургуулийн 8Б ангийн сурагч С.Номин-Эрдэнэ нар тус тус шалгарсан.

Мөн аймгийн ИТХ, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын дарга Б.Ганзориг, аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Батсугир нар улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн ар гэр, үр хүүхдийг хүлээн авч уулзан санал хүсэлтийг сонсож, хүндэтгэл үзүүлсэн.

/2023.09.10/ Аймгийн Дэчинчойнхорлин хийдтэй хамтран Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн гэгээн дурсгалыг хүндэтгэж хэлмэгдэгсдийн төрөл төрөгсөд болон нийт сүсэгтэн олон түмэнд зориулж буяны ном хурах ажлыг зохион байгуулсан.

/2023.09.20/ Нэгдсэн Үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Монгол улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд “Үр дүнд суурилсан удирдлага” сургалтад аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчид, ажлын албаны нийт 120 албан хаагчид хамрагдсан.

“Үр дүнд суурилсан удирдлага” сэдэвт сургалтыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал хамтран зохион байгуулж аймаг, орон нутгийн албан хаагчдад үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагнал гэсэн агуулгын хүрээнд мэдлэг, мэдээллийг олгосон юм.

/2023.09.25/ Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж байгаа “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн хүрээнд зохион байгуулж байгаа сургалтад сум, багийн Засаг дарга нар, Нийгмийн бодлогын мэргэжилтнүүд, Сургуулийн нийгмийн ажилтнууд гэх нийт 27 Хамтарсан багийн 70 гаруй гишүүд хамрагдсан.

Сургалтад хамрагдсанаар хамтарсан багийн гишүүдийн чиг үүрэг, хамтын ажиллагааны талаарх мэдлэг, ойлголт дээшлэх, жендерт суурилсан хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга зүйгээр хангагдах юм.

/2023.09.28/ Аймгийн ИТХ-ын зөвлөлийн 10 дугаар хуралдааныг зохион байгуулж хуралдаанаар аймгийн ИТХ-ын ээлжит 14 дүгээр хуралдааныг 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр хуралдахаар товлосон.

Аймгийн ИТХ-ын даргын шагнал

Тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын даргын “Өргөмжлөл”-өөр 36 иргэнийг шагнаж урамшуулсан.

Аймгийн ИТХ-ын даргын захирамж

Аймгийн ИТХ-ын даргын нийт 24 захирамж батлан гаргасан байна.

Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн тушаал

Тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргын А тушаал 3 гарсан. Өдөрлөг зохион байгуулах тухай-1, Хөрөнгө зарцуулах тухай-2 тушаал батлагдсан гарсан.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС
2023 ОНЫ 07 ДУГААР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

НЭГ: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

Дотоод ажил:

Аймгийн Засаг даргын Захирамж А 65, Захирамж Б 3, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын Тушаал А 8, Тушаал Б 11 батлагдсан байна. Үүнээс аймгийн Засаг даргын 65 А Захирамжийг албан ёсны цахим хуудсанд байршуулсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 210 албан бичиг ирснээс 40 нь хугацаатай албан бичиг ирж хугацаанд шийдвэрлэсэн. Байгууллагаас 120 албан бичиг бусад байгууллага, иргэнд хүргүүлсэн.

Өргөдөл, гомдол, шагнал:

09-р сард иргэдээс аймгийн Засаг дарга, Тамгын газарт хандаж нийт 470 өргөдөл, гомдол ирүүлсний 232 нь Засгийн газрын 11-11 төвөөс ирүүлсэн, 238 нь бичгээр болон иргэдийн санал хүсэлт хүлээн авах 7052-11-11 утсаар, <http://dornogovi.gov.mn/> сайт хаягаар ирсэн байна. Эдгээрийн 13 утсаар болон цахимаар ирүүлсэн өргөдөл байна.

10 дугаар 01-ний байдлаар нийт 121 өргөдөл гомдол судлагдах шатандаа болон хугацаа хоцорч байна.

Эдгээрийн 42 нь хуулийн хугацаа буюу 30 хоног хэтэрсэн байна.

Өмнөх сард хүлээн аваад судлагдаж байсан 24 өргөдөлд хариуг өгөв.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэдийн санал хүсэлт хүлээн авах 7052-11-11 утсаар 358 санал, лавлагаа хүлээн авч холбогдох албан тушаалтанд дамжуулан, хариуг өгөв.

Хүлээн авсан нийт өргөдөл, гомдлын 48,4 хувь нь санал, хүсэлт, 47,5 хувь нь гомдол, 4,0 хувь нь талархал байна.

Төрийн дээд шагнал алдар цол, одон, медалиар шагнуулахаар нийт 140 иргэний тодорхойлолт материалыг хүлээн авч шалган шагналын материалыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэв. Эдгээр нь:

- Монгол улсын гавъяат зүтгэлтэн цолоор – 7,
- Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор – 12,
- Цэргийн гавъяаны улаан тугийн одонгоор - 2,
- Алтан гадас одонгоор – 63,
- Цэргийн гавъяаны одонгоор - 3,
- Хөдөлмөрийн хүндэт медалиар – 50,
- Цэргийн хүндэт медалиар – 3 иргэнийг шагнуулахаар уламжилсан байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШАГНАЛ

- 2023 онд аймгийн хэмжээнд нийт 233 эх “Алдарт эх” нэг, хоёрдугаар одонгоор шагнагдах болзол шаардлагыг хангасан ба эдгээрийн 15 эх нь “Алдарт эх” нэгдүгээр зэргийн одонгоор, 218 эх “Алдарт эх” хоёрдугаар зэргийн одонгоор шагнагдсан байна.

- 2023 оны 09-р сарын 15-ны байдлаар эрхэлсэн салбартаа олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа зүтгэл чармайлтыг үнэлэн 158 иргэнийг аймгийн Засаг даргын шагналаар шагнуулахаар ирүүлсэн материалыг хянан үзэж, “Жуух бичиг”-ээр - 42 “Өргөмжлөл”-өөр – 116 иргэнийг шагнах шийдвэрийг боловсруулан батлуулав.

2022 оны үйл ажиллагаагаар амжилт гарган ажилласан 9 байгууллага, хамт олныг аймгийн “Тэргүүний хамт олон”, 9 иргэнийг аймгийн “Тэргүүний ажилтан”-аар шалгаруулан шийдвэрийг батлуулав.

Мэдээллийн технологийн чиглэлээр:

Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулж буй цаг үеийн мэдээлэлтэй холбоотой 110 мэдээг албан ёсны цахим хуудас болон сайтад байршуулан иргэдэд мэдээлэл хүргэсэн.

ХОЁР: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС:

ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД:

- ✓ 9 дүгээр сард хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг гарган батлуулсан.
- ✓ Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит 12 дугаар хуралдаанаар төлөөлөгчдийн гаргасан саналуудын өөрийн хэлтэст холбогдох ажлуудын биелэлтийг тайлагнасан. Мөн Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит бус 13 дугаар хуралдаанд холбогдох ажлыг хийж, зорилтот бүлгийн иргэдийг түрээслээд өмчлөх орон сууцад хамруулах журам болон танилцуулгыг бэлтгэсэн.
- ✓ Сар бүрийн нөхцөл байдлын талаарх 8,9 дүгээр сарын мэдээллийг Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх хэлтэст тайлагнасан.
- ✓ “Говь консалтинг менежмент” ОНӨААТҮГ-ын дүрмийг боловсрууллаа.
- ✓ Төрийн мэдээлэл сэтгүүлийн шинэ дугааруудыг хүлээн авч, хуулийн санд бүртгэсэн.
- ✓ Хилийн цэргийн 0169 дүгээр ангийн 90 жилийн ойн баярт зориулж дэмжлэг үзүүлсэн.
- ✓ Сумдад улсын, орон нутгийн төсөв, орон нутгийн сангийн хөрөнгөөр 2019 оноос хойш ашиглалтад орсон бүтээн байгуулалтын ажлын жагсаалтыг авах ажлыг хийсэн.

- ✓ Түүнчлэн 7 хоног бүр эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд шинээр орсон эрх зүйн актын талаарх мэдээллийг товч байдлаар бэлтгэн аймгийн ЗДТГ-ын албан хаагчид хүргэж байна.
- ✓ Шүүхэд тухай бүр итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, шаардлагатай баримт бичгүүдийг нотлох баримтаар хүргүүлсэн.

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМАНД ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД:

- ✓ Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд үйлчилж байгаа захиргааны хэм хэмжээний актын хуульд нийцсэн байдлын тайланг хүргүүлэв.
- ✓ Гэмт хэргийн холбогдогч, хохирогч, гэрч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хүргүүлэв.

ЗАСГИЙН ГАЗРЫН 1111-ТӨВД БОЛОН АЛБАН БИЧГЭЭР ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ХҮРЭЭНД:

- ✓ Хууль, эрх зүйн хэлтэст албан бичгээр ирүүлсэн болон Засгийн газрын 11-11 төвд цахимаар ирүүлсэн өргөдлүүдийг хүлээн авч судлан холбогдох ажиллагааг хийж хугацаанд нь хариу өгч ажилласан. Хугацаа хэтэрсэн, хариу өгөөгүй өргөдөл гомдолгүй ажиллаж байна.

ЗАХИРАМЖ, ТУШААЛЫН ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛИЙГ ХЯНАХ, АЛБАН ХЭРЭГ, ХӨТЛӨЛТИЙН СТАНДАРТАД НИЙЦҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ:

- ✓ Аймгийн ЗДТГ-ын алба хаагчдаас боловсруулсан 55 захирамж, тушаалыг хянаж тухай бүр зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

- ✓ 2023-2024 оны авлигын эсрэг жил болгон зарласантай холбогдуулан Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллагын “Бэст хөтөлбөр”-тэй хамтран “Авлигын эрсдлээс урьдчидан сэргийлэх, авлигын эсрэг хууль тогтоомж” сэдэвт сургалтын 9 дүгээр сарын 8-ны өдөр зохион байгуулж холбогдох байгууллагын алба хаагчдыг хамруулсан. Сургалтаар дараах сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг хийсэн:
 - Хуульч, хууль зүйн ухааны доктрант Ц.Амарсанаа “Төрийн албаны төлөвшил”
 - Амар оюуны хөрөнгө оруулалт ХХК-ийн захирал, сургагч багш Ч.Сайхнаа “Ёс суртахуун, ашиг сонирхлын зөрчил”
- ✓ Дэвжээ -2023 тэмцээнийг 10 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулахаар удирдамжийг бүх сум, агентлаг байгууллагуудад хүргүүлээд байна.

ХҮНИЙ ЭРХИЙН ХҮРЭЭНД:

- ✓ Хүний эрхийн үндэсний комиссоос зохион байгуулсан “Манай ангид - Хүний эрхийн түгээмэл тунхаглал” уриалгад нэгдэж, аймгийн хэмжээнд өрнүүлсэн. Уг уриалгад аймгийн хэмжээнд 22 сургуулийн 16000 гаруй сурагчид, 7500 гаруй багш нар нэгдлээ. Энэ хүрээнд сурагчдад Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг таниулсан хичээлийг үндэсний бичигтэй хослуулан 3 үе шаттайгаар орсон. Уг уриалгын хүрээнд богино хэмжээний бичлэг хийж цахим байршуулсан.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙГ ТҮРЭЭСЛЭЭД ӨМЧЛӨХ ОРОН СУУЦАД ХАМРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

1. Зорилтот бүлгийн иргэдийг түрээслээд өмчлөх орон сууцад хамруулах ажлыг хүрээнд иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллаж байна.
2. Түрээслээд өмчлөх орон сууцад хамрагдахаар хүсэлт өгсөн иргэдийг сонгон шалгаруулах ажлын хүрээнд Сайншанд сумын багийн иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хэсэгт ажилласан.

ГУРАВ. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС

Санхүү, төрийн сангийн чиглэлээр:

Зорилтод арга хэмжээний хэрэгжилтийн явц:

- 2023 оны 9-р сарын орлогын төлөвлөгөө 71.3 тэрбум төгрөгний орлого төвлөрүүлэхээс орон нутгийн төсөвт 42.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрч 28.8 сая төгрөгийн орлого тасарч 59.6%-ийн биелэлттэй байна.
- Шилэн дансны хуулийн дагуу сайтад тухай бүр байршуулах төсөв хөрөнгөтэй холбоотой 25 захирамж байршуулсан.
- Монгол хүмүүн Монгол соёл төслийн хэрэгжилтийг 8 суманд хянаж шалгасан.
- ХТТШ, ЗГҮАХ-ийн хэлтэст хамааралтай заалтын хэрэгжилтийг гаргаж, ХШҮХ-т хүргүүлсэн.
- Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч, бүртгэлийн мэргэжилтний 2023 оны хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийг гарган сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын газарт хүргүүлсэн.
- Нэмэлт төсвийн 15 байгууллагын зарцуулах эрхийг үндэслээд 68.5 сая төгрөгийн баримтын бүрдлийг үндэслээд эрхийг нээсэн.
- Музей сургалт судалгааны төв, Насан туршийн боловсролын төвийн дарга өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Эрхийн бүртгэлийн санд холбогдох баримт бичгийг холбон төлбөр тооцоо хийгдэх нөхцийг бүрдүүлсэн.

- Татварын удирдлагын нэгдсэн системд бүргэгдээгүй 288 дансыг харьяа сумдад жагсаалтаар хүргүүлэн бүртгэх ажлыг хийж байна.
- Төрийн сангийн удирдлагын цахим системээр дамжуулан 2023.09.01-2023.09.30-ны хооронд цахимаар 1935 гүйлгээг хүлээн авснаас 1920 гүйлгээг батлан сангийн яаманд дамжуулсан, төрийн сангийн үйл ажиллагааны журам болон холбогдох хуулийг зөрчсөн 15 гүйлгээг буцаасан.
- Хэлтэст нийт 50 бичиг ирснээс 50 бичиг албан хэрэгцээнд авсан.

Статистикийн хэлтэс:

Зорилтод арга хэмжээний хэрэгжилтийн явц:

- Дорноговь аймгийн нийгэм, эдийн засгийн 2023 оны 08 дугаар сарын танилцуулгыг боловсруулж, хэлтсийн цахим хуудас болон фэйсбүүк хуудсанд байршуулан, 600 гаруй хэрэглэгчдэд цахимаар, тархаасан.
- Гол нэр төрлийн 12 бараа бүтээгдэхүүний үнэ болон нэмэлтээр 54 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг долоо хоног бүрийн Даваа гаригт Сайншанд сумын хүнсний зах, дэлгүүрээс судалж, програмд шивэн, хугацаанд нь Үндэсний статистикийн хороонд дамжуулав.
- Сар бүрийн 21-нд хэрэглээний үнийн 313 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг аймгийн төвийн хүнсний зах, дэлгүүрээс судалж программд шивэн, хугацаанд нь Үндэсний статистикийн хороонд дамжуулсан. Мөн Айраг, Даланжаргалан, Эрдэнэ, Замын-Үүд, Хатанбулаг сумдын мэргэжилтнүүд 145 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийг программд шивж Үндэсний статистикийн хороонд дамжуулав.
- Аж үйлдвэрийн сарын мэдээ /АҮ-1/, зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагааны сарын мэдээ /А-ЗГ-1, А-ЗБ-1/, худалдааны салбарын сарын /ХУ-1/ мэдээ, тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмжийн импортын үнийн судалгаа/ТХХТИҮ/, хөдөө аж ахуйн салбарын /ХАА-1, ХАА-2, ХАА-3, ХАА-7, ХАА-8, ХАА-10/ мэдээг сум, аж ахуйн нэгж, иргэдээс цуглуулан авч нэгтгэн нягтлан шалгаж, программд шивж байна.
- “Цаг ашиглалтын судалгаа”-ны 09-р сарын хүрээнд Эрдэнэ сум сонгогдож, мэдээлэл цуглуулагч Д.Мөнхболор ажиллаж байна. Судалгааны хяналтын ажлыг мэргэжилтэн А.Амарзаяа гүйцэтгэж байна.
- Өрхийн нийгэм, эдийн засаг, Ажиллах хүчний судалгааны 09-р сарын судалгаанд судлаач Б.Мөнх-Эрдэнэ, А.Дамчой нар ажиллаж, түүвэрт сонгогдсон Сайншанд, Даланжаргалан, Замын-үүд, Хатанбулаг, Улаанбадрах, Өргөн, Эрдэнэ сумдын 78 нийт өрхөөс мэдээллийг цуглуулан ажиллаж байна.
- “Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл,Нэмүү өртгийн сүлжээний тооцооны туршилт судалгаа”-нд түүвэрт сонгогдсон Сайхандулаан сумын 37 өрхөөс мэдээлэл цуглуулан ажиллаж байна.

- Статистикийн тухай хуулийн дагуу 5 жил тутамд “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”-г зохион байгуулдаг билээ. Улсын хэмжээнд тус судалгаа нь 10 дугаар сарын 1-нээс эхлэх юм. Иймд аймгийн хэмжээнд түүвэрт сонгогдсон 18 нэгжийн түүврийн хүрээг сайжруулах тодруулгын ажил 2023 оны 08 сарын 25-ны өдрөөс 09 сарын 15-ны хооронд амжилттай явагдаж 3675 өрхийн мэдээллийг торуулж 100.0 хувь дууссан.
- Үндэсний Статистикийн Хороо “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны түүврийн хүрээний чанарыг сайжруулах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх нь” сэдвийн хүрээнд төвийн болон зүүн бүсийн сургалтыг энэ сарын 25, 26-нд зохион байгууллаа. Сургалтад Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Хэнтий зэрэг Төвийн болон зүүн бүсийн нийт 10 аймгийн албан хаагчид оролцлоо. Энэ үеэр статистикийн салбарын стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, салбарын үйл ажиллагааны шинэчлэл, мэдээллийн чанарыг хянах, үнэлэх журмын хэрэгжилтийг хангах талаар онцоллоо. Мөн нийгмийн статистикийн мэдээ, өрхөд суурилсан судалгааны чанар, бодит байдал, статистикийн мэдээ, тооллого, судалгааны чанар, баримтжуулалт болон үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх хүрээнд мэдээлэл хүргэлээ. Түүнчлэн Ази Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын албан ёсны статистикийн бүсийн зөвлөх Ян Смит аймгийн Статистикийн хэлтсийн дарга нартай салбарын үнэлгээний ажлын хүрээнд уулзалт зохион байгуулсан.

Татварын хэлтэс:

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц:

- Улс ба орон нутгийн төсөвт **5,840,2** сая төгрөгийн татварын орлого төвлөрүүлсэн.
- Тайлант хугацаанд цахим татварын мэдээллийн шинэ системийг хэрэгжүүлэн 5 төрлийн нийт 1125 татварын тайлан, 273 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн ажилласан. Тайлант хугацаанд 70521288 нэгдсэн дуудлагын дугаараар 422, өрөөгөөр - 482 татвар төлөгчдөд Татварын хууль, НӨАТ-ын урамшууллын систем, Цахим татварын мэдээллийн шинэ системийн заавар зөвлөгөөг өгсөн.
- Дуудлагаар татварын үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ орон нутагт хэрэгжиж 1800-1288-д 1311 дуудлага ирж зөвлөгөө мэдээллийг өгч, ирүүлсэн 54 гомдлыг хуваарилан 39 -г шийдвэрлэж баталгаажуулсан.
- Аймгийн Улсын бүртгэлээс шинээр үүссэн 2 хуулийн этгээдийн мэдээллийг ТУНС-д бүртгэж, НӨАТ суутган төлөгчөөр 22 хуулийн этгээдийг бүртгэсэн байна.

- Дорноговь татварын хэлтэс фейж хуудсаар 113 мэдээ мэдээллийг 72800 татвар төлөгчдөд түгээн шинээр 244 харилцагч нэгдсэн. Чатаар 135 иргэнд хариу мэдээлэл өгч асуудлыг шийдвэрлэсэн.
- Газар шилжилт хийж байгаатай холбогдуулан газрын төлбөрөө төлж барагдуулсанд хяналт тавих- 17 татвар төлөгч газар эзэмших эрх шилжүүлж 1,251,480 төгрөгийн төлбөрөө бүрэн төлж барагдуулсан.
- 2023.09.19-29 -ний өдрүүдэд Сайншанд, Дэлгэрэх, Улаанбадрах, Иххэт, Айраг, Өргөн, Алтанширээ, Хатанбулаг сумуудад үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийн цахим төлбөрийн баримтад хяналт шалгалт хийж, мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч байгууллагын фэйж хуудаст байршуулан ажилласан.

Орон нутгийн өмчийн газар :

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц

➤ **Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 10 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг хялбаршуулсан цахим системээр зарласан. Үүнд:**

1. Айраг сумын уурын зуухны хүчин чадлыг нэмэгдүүлэх ажил
 2. Хөгжим, аппаратур, тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг худалдан авах ажил
 3. Цагдаагийн газраас Дэнжийн пост хүртэл авто зам дагуу явган хүний зам, дугуйн зам барих ажил /1.5 км/
 4. Асрамжийн газрын үерийн усны далан хийх ажил
 5. Хатанбулаг сумын Ханги боомтын ЭМТ-ийн гүний худгийн гадна цахилгаан, гадна усан хангамж, ариутгах татуурга, гадна холбооны шугам сүлжээ, гадна тохижилт, худгийн барилга, гадна хамгаалалтын өргөст торон хашаа угсрах ажил
 6. Алтанширээ сум, Дэлгэрэх сум, Иххэт сум, Хөвсгөл сум, Эрдэнэ сум, Замын-Үүд сумын Цагдаагийн газар,туулах чадвар сайтай жийп автомашин худалдан авах ажил
 7. Саранхөхөө театрын барилгын хэсэгчилсэн дотор засварын ажил
 8. "Цахим Дорноговь" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд программ хангамж, компьютер, тоног төхөөрөмж худалдан авах ажил
 9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний Хөгжлийн төвийн барилга барих ажил
 10. Саранхөхөө театрын барилгын хэсэгчилсэн дотор засварын ажил
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу зарласан дараах төсөл арга хэмжээний тендерийн хариу мэдэгдэл хүргүүлж, гэрээ байгуулах эрх олгогдсон. Үүнд:**

1. Алтанширээ сум, Дэлгэрэх сум, Иххэт сум, Хөвсгөл сум, Эрдэнэ сум, Замын-Үүд сумын Цагдаагийн газар,туулах чадвар сайтай жийп автомашин худалдан авах ажил
 2. Айраг сумын уурын зуухны хүчин чадлыг нэмэгдүүлэх ажил
 3. Аймгийн Цагдаагийн газарт туулах чадвар сайтай жийп автомашин худалдан авах
 4. Саранхөхөө театрын барилгын хэсэгчилсэн дотор засварын ажил
 5. Улаанбадрах сумын нэгдсэн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ нэмж татах ажил
 6. Хөрөнгө оруулалтын ажлын зураг төсөв гүйцэтгэх зардал
 - **Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу зарласан дараах төсөл арга хэмжээнд нээлт хийж, нарийвчилсан үнэлгээг хийж байна.**
1. Цагдаагийн газраас Дэнжийн пост хүртэл авто зам дагуу явган хүний зам, дугуйн зам барих ажил /1.5 км/
 2. Сайншанд сумын 6-р сургуулийн хашаан дотор автозам барих ажил
 3. Саранхөхөө театрын шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах
 4. Саранхөхөө театрын барилгын хэсэгчилсэн дотор засварын ажил
 5. Хамарын хийдийн дурсгалт газрын гэрэлтүүлэг хийх ажил /Хамарын хийдээс Шамбалын орон хүртэл/

Санхүүгийн хяналт, аудитын алба:

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц:

- Аймгийн Засаг даргын баталсан 2023 оны санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж байна.
- Монгол Улсын Сангийн сайдын баталсан 2023 оны СХШХ/02 тоот удирдамж, албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан 12 тоот удирдамжийн дагуу аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021, 2022 онуудын санхүү аж ахуйн үйл ажиллагаа болон нийгмийн даатгалын сангуудад хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн хяналт шалгалтын нэгдсэн акт, холбогдох судалгааг 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 88 тоот албан бичгээр Сангийн яамны санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт, 89 тоот албан бичгээр аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст тус тус хүргүүлсэн.
- Аймгийн Нэгдсэн эмнэлэгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүнгийн талаар аймгийн Засаг даргад 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 97 тоот албан бичгээр, Эрүүл мэндийн сайдад 98 тоот албан бичгээр, Эрүүл мэнийн даатгалын ерөнхий газарт 99 тоот албан бичгээр, аймгийн Эрүүл мэндийн газарт 100 тоот албан бичгээр, аймгийн Эрүүл мэндийн

даатгалын хэлтэст 101 тоот албан бичгээр, Нэгдсэн эмнэлэгт 102 тоот албан бичгүүдээр тус тус хүргүүлсэн.

- Аймгийн эрүүл мэндийн газрын 2023 оны 5/2 тоот албан бичиг, албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан 13 тоот удирдамжийн дагуу Айраг сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн, хяналт шалгалтын нэгдсэн акт, тэмдэглэлийг 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 104 тоот албан, аймгийн Эрүүл мэндийн газарт 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 106 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.
- Энэ сард энэ оны актын төлбөрийн үлдэгдлээс **1,568,1** мянган төгрөгийг барагдуулж орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэн.
- . Байгууллагын хэмжээнд 7 ирсэн бичиг, 25 явуулсан бичиг, 4 өргөдөл, А тушаал 2, Б тушаал 1-г тус тус боловсруулж, бүртгэлжүүлсэн.

Статистикийн хэлтэс:

- **Зорилтод арга хэмжээний хэрэгжилтийн явц:**
 - Аймгийн Засаг даргын баталсан 2023 оны санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж байна.

1. “Цаг үеийн ажлын мэдээлэл”

1. Иргэн Б.ОюунЭрдэнийн гаргасан өргөдлийн дагуу албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан 17 тоот удирдамжийн дагуу Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2017-2023 онуудын цалингийн бодолт олголтод төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн, шалгалтаар ээлжийн амралтын цалинг дутуу олгосныг эргүүлж олгуулахаар санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 1 акт тогтоолоо. Шалгалтын нэгдсэн акт тэмдэглэлийг 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 156 тоот албан бичгээр иргэн Б.ОюунЭрдэнэд, аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт 157 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.

2. Сайншанд сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн 2021-2022 оны санхүү аж, ахуйн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж дуусган шалгалтын нэгдсэн актыг 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 155 тоот албан бичгээр хүргүүлсэн.

3. Албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан 18 тоот удирдамжийн дагуу Сайншанд сумын хүүхдийн 10 дугаар цэцэрлэгийн санхүү аж ахуйн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж дуусгаж, шалгалтын дүнгийн хурлыг хийсэн.

4. Албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан 19 тоот удирдамжийн дагуу Сайншанд сумын хүүхдийн 11 дүгээр цэцэрлэг, 20 тоот удирдамжийн дагуу Сайншанд сумын хүүхдийн 13 дугаар цэцэрлэг, 21 тоот удирдамжийн дагуу Сайншанд сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгүүдийн 2021-2022 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалт үргэлжилж байна.

5. Сайншанд сумын багуудын иргэдийн нийтийн хуралд байгууллагын бүх албан хаагчид оролцсон.

6. Аймгийн Татварын хэлтсээс 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан Хялбаршуулсан татварын тайлан, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, буцаан олголт сэдэвтэй сургалтанд байгууллагын нягтлан бодогч, нярав нар хамрагдсан.

7. Сайншанд сумын 3 дугаар багийн нутагт дэвсгэрт байрлах байгууллагын хуваарьт газартаа их цэвэрлэгээг 2 удаа хийсэн.

8. 7 хоног бүрийн даваа гарагт байгууллагын мэдээллийн цагийг хийж байгаа ба 4 удаагийн мэдээллийг хийж гүйцэтгэсэн.

9. Энэ сард ирсэн бичиг 14, явуулсан бичиг 32, А тушаал 2, Б тушаал 2, 1 өргөдөлийг бүртгэж, шийдвэрлэсэн.

10. Энэ сард 3355,0 мянган төгрөгийн актын төлбөрийг барагдуулсан.

11. Эм эргэлтийн сан ОНӨААТҮГазрын 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалтаар тогтоогдсон санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 77094,8 мянган төгрөгийн 12 актыг баталгаажуулахаар Дорноговь аймаг дах сум дундын анхан шатны шүүхэд шилжүүлсэн.

ДӨРӨВ: ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭС

Хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн чиглэлээр:

- 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний зураг, төсвийн ажлыг эрчимжүүлж, 10 сард багтаан батлуулахаар ажиллаж байна.

- Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны гүйцэтгэлийн аудитын 2 албан шаардлага, 1 актын төлбөрийн биелэлийг албан бичгээр хүргүүлж, fas.audit.mn Аудитын системд биелэлтийг тайлагнасан.

- Алтанширээ, Дэлгэрэх, Иххэт, Хөвсгөл, Эрдэнэ сумд, Замын-Үүд сумын Цагдаагийн газарт туулах чадвар сайтай жийп автомашин нийлүүлэх ажил, Багийн Засаг дарга нарын албан хэрэгцээнд мотоцикль нийлүүлэх, Улаанбадрах сумын нэгдсэн дулаан, цэвэр бохир усны шугам сүлжээ нэмэх ажил, Аймгийн Цагдаагийн газарт автомашин нийлүүлэх зэрэг 4 төсөл арга хэмжээний тендерт шалгарсан компаниудтай ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан.

- Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлаас 5 төсөл арга хэмжээний 436,0 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг нээж Төрийн сангийн хэлтэст өгч гүйлгээ хийгдсэн.

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2 төсөл арга хэмжээний санхүүжилт хүссэн гүйцэтгэлийг PIMIS программд шивж Сангийн яам руу илгээсэн. (Саранхөхөө театрын барилгын ҮНЗ, Даланжаргалан сумын ЭМТ барилга)

- Нэгдсэн эмнэлэгийн цахилгаан шатны гүйцэтгэгч Мастер лифт ХХК-ийн захирал Эрэнбаатар, Нэгдсэн эмнэлэгийн дарга Энхбаяр нартай уулзаж 10 дугаар сарын 03-ны өдөр гэхэд цахилгаан шатны ажлыг дуусгавар болгох, мөн засвар хийгдсэн зардал 2,1 сая төгрөгийг төлж барагдуулах талаар үүрэг өгсөн.

- 2024 онд аймгийн Орон нутгийн төсвөөр хийгдэх төсөл, арга хэмжээний саналын жагсаалт ирүүлэх тухай албан бичгийг сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн.

Уул уурхайн чиглэлээр:

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой 6 аж ахуйн нэгжийн өргөдлийг хүлээн авч 2 өргөдлийг шийдвэрлэн татгалзсан хариу өгч, 4 өргөдлийг хянан Ашигт малтмал, Газрын тосны газрын кадастрын бүртгэлийн системд бүртгэсэн.

Алтанширээ, Өргөн сумын нутагт Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын 2 тусгай зөвшөөрөл шинээр олгосон.

Өргөн сумын Засаг даргаас Бичил уурхайгаар ашигт малтмал, ашиглахтай холбоотой ирсэн хүсэлтийг судлан үзэж Ашигт малтмал, Газрын тосны газарт дүгнэлт гаргуулах хүсэлтийг хүргүүлсэн. Мөн Өргөн сумын 2 талбайд гаргасан дүгнэлтийг хүлээн авч орон нутгийн тусгай хэрэгцээнд авах чиглэлийг сумын Засаг даргад хүргүүлэн ажилласан.

Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яамны төлөвлөгөөт хяналт шалгалт хийх 006-00/005 дугаартай удирдамжийн дагуу уул уурхай, байгаль орчин, газрын тос, автотээвэр, хөдөлмөр, эрчим хүчний чиглэлээр Улсын байцаагч нар уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 27 компанид хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Шалгалтын дагуу сонсох ажиллагаа явуулах, материалыг нягтлан шалгах ажлууд хийгдэж байна.

Байгаль орчны чиглэлээр:

Япон улсын “Жайка” төслийн санхүүжилтээр хэрэгжиж буй гүн суулган тарих аргаар “Дорнын говийн цөлөрхөг бүсийн хуурай, хүйтэн газар нутгийг ургамалжуулах үйл ажиллагааг дэмжих техникийн хамтын ажиллагаа” төсөл нь Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дэргэдэх мод үржүүлгийн талбайд амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд Нийгата мужийн Гадаадтай технологийн талаар хамтран ажиллах нийгэмлэгийн гишүүн төслийн менежер Мэгүро Шюүжи ахлагчтай 8 хүний бүрэлдэхүүнтэй мэргэжлийн эрдэмтэн судлаачдын баг Монгол талаас 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байгаа ба төслийн үйл явцын тайланг 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр танилцуулсан. Төслийн багийн зүгээс экологийн боловсрол олгох, соён гэгээрүүлэх чиглэлээр төслийн багийн зүгээс Ерөнхий боловсролын 1-р сургуультай хамтран ажиллахаар тохирч, сургуулийн сурагчдад Говийн цэцэг ургамлын үр түүх чиглэл өгсөн бөгөөд зуны даалгавраа хэрхэн биелүүлсэн талаар ярилцаж, гар урлал хийх, Сайншанд сумын Ерөнхий боловсролын сургуулиудын Биологийн багш нарыг оролцуулан багш, сурагчдад Монгол улс, Дорнын говийн цөлөрхөг бүсэд, гүн суулган тарих аргаар хуурай, хүйтэн

газар нутгийг ургамалжуулах үйл ажиллагааг дэмжих техникийн хамтын ажиллагааг сургалтыг зохион байгуулсан.

Жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээний чиглэлээр:

- Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр сургалт мэдээллийг давхардсан тоогоор 45 аж ахуйн нэгж, 26 иргэнд өгч ажилласан.

- Аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн судалгаа мэдээллийг гарган холбогдох газарт хүргүүлсэн. Одоогоор 187 аж ахуй нэгжийн 220 цэг үйл ажиллагаа явуулж байна.

- Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр 60 гаруй аж ахуйн нэгжийн хүсэлтийг E Mongolia цахим хуудсаар хүлээн авч хянаад байна. Хүнсний аюулгүй байдалд тавих 3 удаагийн зөвлөн туслах ажлыг зохион байгуулж давхардсан тоогоор 140 гаруй иргэн аж ахуйн нэгжийг хамруулсан.

- Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн нарийвчилсан судалгаа мэдээллийг “Хөгжлийн шийдэл” ТББ-ыг санхүүжилтээр “Говийн хөх салхи” НҮТББ гүйцэтгэсэн. Судалгаанд 1000 бизнес эрхлэгч хамрагдсан.

- 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 9 сум “Хоршоо хөгжүүлэх сан”-гаас 44 төсөлд 1.3 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Дэд бүтцийн чиглэлээр:

- Төв суурин газрын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр албан даалгавар гарч, бэлтгэл ажлыг эрчимжүүлээд байна.

- Аймгийн хэмжээнд төвлөрсөн дулааны шугамд холбогдсон сумдад төлөвлөгөөт хугацаанд нь халаалт өгөх бэлтгэл хангасан.

- Сайншанд-Хамарын хийд чиглэлийн 26,6 км орон нутгийн чанартай авто замын засвар, шинэчлэлтийн ажлыг “Дорноговь АЗЗА” ТӨХК гүйцэтгэж улсын комисст хүлээлгэн өгсөн.

- Сайншанд сумын 6 дугаар багын авто замыг нөхөх, явган хүний зам, дугуй зам барих ажлыг “Дорноговь АЗЗА” ТӨХК гүйцэтгэж улсын комисст хүлээлгэн өгсөн.

- Авто замын засвар арчлалтын 2023 оны төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл 78 хувьтай үргэлжилж байна.

- Цахилгаан хангамжийн 2023 оны төлөвлөгөөт ажлын хэрэгжилт 80 гаруй хувьтай үргэлжилж байна.

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр:

- Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 03 дугаар албан даалгаврын хүрээнд хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажил 2023 оны 09 дүгээр сарын байдлаар 51 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.

- Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг орон нутагт эрчимжүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, Дорноговь аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2” хөтөлбөрийн хүрээнд “Намрын ногоон өдрүүд-2023” үзэсгэлэн худалдааг 09 дүгээр сарын 11, 12-ны өдрүүдэд Сайншанд суманд 20 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Энэхүү үзэсгэлэн худалдааг аймгийн Засаг дарга О.Батжаргал нээж мэндчилгээ дэвшүүлж амжилт хүсч, аймгийн Засаг даргын орлогч Г.Март, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ж.Наранболд нар шилдэг оролцогч нарт шагнал гардуулсан. Мөн үзэсгэлэн худалдааны үеэр хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлсэн 10 тариаланчдад Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллагатай хамтран гэрчилгээ гардуулсан. “Намрын ногоон өдрүүд-2023” үзэсгэлэн худалдаанд нийт 12 сумын 106 иргэн, аж ахуйн нэгж байгууллага оролцлоо.

- Газар эзэмшүүлэх, ашиглуулах, шилжүүлэхтэй холбоотой аймгийн Засаг даргын 8 захирамж гаргасан.

-“Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажил зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/619 дугаар, “Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комисс томилох тухай” аймгийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн А/670 дугаар тус тус захирамж гаргасан.

-Дундговь, Сүхбаатар, Хэнтий, Говьсүмбэр, Хил хамгаалах ерөнхий газрын даргад аймгийн малчин иргэдийг отроор нутаглуулах хүсэлтийг албан тоотоор тус тус хүргүүлсэн.

ТАВ: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

Нэг. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр:

1.Шинээр гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч, бүртгэл хөтөлж, удирдлагуудад танилцуулах

2023.09.05-ны өдрийн 13/01 дүгээр “Зорилтот хөтөлбөр батлах тухай” тогтоол, 13/02 дугаар “Тогтоол хүчингүй болгох тухай” тогтоол, 13/03 дугаар “Говь кансалтинг менежмент” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийг шинэчлэн батлах тухай тогтоол, 13/04 дүгээр “Аймгийн сонгуулийн хороог татан буулгах тухай” тогтоол, 13/05 дугаар “Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг дэмжих тухай” тогтоол, 13/06 дугаар “Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг дэмжих тухай” тогтоол, 13/07 дугаар “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, 13/08 дугаар “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, 2023.07.19-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын тогтоол, 2023.08.16-ны өдрийн “Нийслэл Улаанбаатар

хотод гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, нийслэлийн хот төлөвлөлт, газар зохион байгуулалттай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоол, 2023.08.16-ны өдрийн “Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг батлах, тогтоолд нэмэлт оруулах тухай”, 2023.08.23-ны өдрийн “Баг, хорооны Засаг дарга нарыг чадавхжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай”, 2023.08.23-ны өдрийн “Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай”, 2023.08.30-ны өдрийн “Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай”, 2023.08.30-ны өдрийн ““Эрүүл шүд” арга хэмжээг хэрэгжүүлэх тухай”, 2023.08.30-ны өдрийн “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоол, 2023.09.13-ны өдрийн ““XV.02.Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хэрэгжүүлж байгаа төрийн өмчит компаниудын сэргэлтийн ажлын явцын талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулсан тухай” Засгийн газрын хуралдааны тэмдэглэл зэргийг хяналтад авч, удирдлагуудад танилцуулан, бүртгэлжүүлсэн.

2. Монгол Улсын сайд нартай Аймгийн Засаг дарга байгуулсан гэрээг цахимд оруулах

Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд болон Дорноговь аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулах гэрээ, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайд, Дорноговь аймгийн Засаг дарга хоорондын гэрээ, Монгол Улсын Сангийн сайд болон Дорноговь аймгийн Засаг даргын 2023 онд хамтран ажиллах гэрээ, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас Дорноговь аймгийн Засаг даргатай 2023 онд хамтран ажиллах гэрээ, Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Дорноговь аймагт төлөөлөн 2023 онд хэрэгжүүлэх гэрээ, Зам, тээврийн хөгжлийн сайд, Дорноговь аймгийн Засаг дарга нарын хамтын ажиллагааны гэрээ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төсвийн ерөнхийлөн захирагч болон Дорноговь аймгийн Засаг даргын хооронд Төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн 2023 онд хэрэгжүүлэх гэрээ, Монгол Улсын Эрүүл мэндийн сайд Дорноговь аймгийн Засаг даргатай 2023 онд хамтран ажиллах гэрээ, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд болон Дорноговь аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээ зэргийг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд /<https://new.unelgee.gov.mn/> байршуулсан.

3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлан хүлээлгэн өгөх

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний 8 дугаар сарын хэрэгжилтийн тайланг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд /<https://new.unelgee.gov.mn/> байршуулсан.

4.Цаг үеийн ажлууд

Түрээсийн орон сууцны сугалаа явагдах гэж байгаатай холбогдуулан төрийн албан хаагч нарын судалгааг авч, 8 багийн төрийн албан хаагчийн судалгааны мэдээллийг нэгтгэсэн.

Архивт хүлээлгэн өгөх 2022 оны баримт бичгүүдийн стандарт архивын нэгж үүсгэхэд хангалтгүй байсан учраас дахин шаардлагатай арга хэмжээг авч ажилласан.

Монгол улсын сайд нар Дорноговь аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Дорноговь аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, дэд болон зорилтот хөтөлбөрүүдийн жилийн эцсийн тайлан авах хугацааг гаргасан.